



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 22 өдөр

Дугаар A/70

Улаанбаатар хот

ШУТИС-ийн Чанарын бодлого, зорилтыг батлах тухай


ШУТИС-ийн дүрмийн 4.14.2, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн Захирлын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/209 тоот тушаал, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн “Чанарын бодлого”-ыг нэгдүгээр, “Чанарын зорилтод хүрэх төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Чанарын бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ШУТИС-ийн дэд захирлууд, бүрэлдэхүүн сургуулийн захирлуудад даалгасугай:

- a. “Чанарын бодлого”-д хавсралтаар тусгагдсан “Чанарын зорилтод хүрэх төлөвлөгөө”-г ШУТИС-ийн бүрэлдэхүүн, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх;
- b. Чанарын бодлого, зорилтыг их сургуулийн хэмжээнд мэдээлж, ойлгуулан, хүртээмжтэй байлгах;

3. “Чанарын бодлого”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал /Ц.Баатархүү/-д даалгасугай.

ЗАХИРАЛ  БОЧИРБАТ



	ЧАНАРЫН БОДЛОГО MUST-QC-RP01	Эхний хэвлэлт	2019.03.22
		Өөрчилсөн олноо	-
		Өөрчлөлтийн дугаар	0

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү бодлого нь ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцоонд дээд удирдлагаас өгч буй амлалт, зарчмыг илэрхийлэхэд оршино.
- 1.2 “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “ШУТИС-ийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр (2019-2024)”, Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага ISO 9001:2015 стандарт зэрэг нь энэхүү бодлогын эрх зүйн үндэслэл болно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

Чанарын бодлого нь ШУТИС болон түүний үйл ажиллагаанд оролцогч, сонирхогч талуудад хамаарна.

ГУРАВ. ЧАНАРЫН БОДЛОГЫН ТОДОРХОЙЛОЛТ

“Олон улсын стандартад нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлж, мэдлэгт суурилсан нийгмийг цогцлоох манлайлагчдыг бэлтгэдэг судалгааны их сургууль болно.”

Чанарын зорилт:

- 3.1 ШУТИС-ийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх
- 3.2 ШУТИС-ийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох
- 3.3 Сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх
- 3.4 Хүний нөөцийн сургалт, хөгжлийг дэмжих
- 3.5 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх
- 3.6 Харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 **Чанарын бодлого:** Их сургуулийн үйл ажиллагааны чанарт хамаарах зорилго, чиглэл.
- 4.2 **Чанарын зорилт:** Чанарын талаар хийхээр буюу хүрэхээр зорьж, эрмэлзсэн зүйлс. Энэ нь чанарын бодлогыг хэрэгжүүлэхийн тулд дэвшүүлсэн ажлын төлөвлөгөө юм.
- 4.3 **Боловсролын үйлчилгээ:** Сургах, суралцах, судлах замаар суралцагчдад чадамж (мэдлэг, ур чадварыг ашиглах чадвар)-ийг эзэмшүүлэх, хөгжүүлэхийг дэмжих үйл явц.
- 4.4 **Хэрэглэгчийн сэтгэл ханамж:** Боловсролын байгууллагын хэрэглэгч буюу суралцагч, тэдний эцэг эх, ажил олгогч, ажилтны шаардлага биелэгдсэн түвшин.



ТАВ. ХАРИУЦЛАГА, ЭРХ ҮҮРЭГ

- ШУТИС-ийн Захирал
 - ШУТИС-ийн Захирлын зөвлөлөөс санал болгосон Чанарын бодлого, зорилтыг тушаалаар баталгаажуулна.
- ШУТИС-ийн Захирлын зөвлөл
 - Чанарын бодлогын нийцэл, тохиромжтой байдалд 2 жил тутамд дүн шинжилгээ хийнэ.
 - Чанарын зорилтод хүрэх төлөвлөгөөний хэрэгжилт болон үр дүнд жил бүр дүн шинжилгээ хийнэ.
 - Чанарын бодлого, зорилтыг үнэлж, зөвлөмж гаргана.
- ШУТИС-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн удирдлагын төв нэгж
 - Чанарын бодлогын нийцэл, тохиромжтой байдалд дүн шинжилгээ хийх ажлыг санаачлан, хэлэлцүүлнэ.
 - Чанарын зорилтын хэрэгжилт, үр дүнг үнэлж тайлагнана.
 - Чанарын бодлого, зорилтод өөрчлөлтийг тусгаж, боловсруулна.
 - Чанарын бодлого, зорилтыг их сургуулийн хэмжээнд мэдээлж, ойлгуулан, хүртээмжтэй байлгана.
- Нийт багш, ажилтан
 - ШУТИС-ийн Чанарын бодлого, зорилтыг ойлгож, хэрэгжүүлж ажиллана.
 - ШУТИС-ийн бүрэлдэхүүн нэгж бүр хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд холбогдох чиг үүргийн дагуу Чанарын зорилтыг нарийвчлан тусгаж, төлөвлөнө.

ЗУРГАА. БОДЛОГЫН ЗАРЧИМ

- 6.1 Суралцагч, тэдний эцэг эх ажил олгогч, ажилтнуудын хүлээлт ба хэрэгцээнд төвлөрнө.
- 6.2 ШУТИС-ийн бүх шатны нэгж дэх манлайлагчийн үнэт зүйл, загварыг бий болгож, хэвшүүлнэ.
- 6.3 Их сургуулийн чанарын менежментийн тогтолцоонд хүн бүрийг оролцуулж, тэдний чадамжийг хөгжүүлнэ.
- 6.4 Үйл ажиллагааг ойлгомжтой, харилцан уялдаатай (дэс дараалал) болгоход үйл явцын арга, хандлагыг ашиглана.
- 6.5 Гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулна.
- 6.6 Өгөгдөл, мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргана.
- 6.7 Харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэнэ.
- 6.8 Нийгмийн өмнө хариуцлагатай байна.
- 6.9 Боловсролын бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй, эрх тэгш байлгана.
- 6.10 Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.
- 6.11 Боловсролын ёс зүйн хэм хэмжээг баримтална.

ШУТИС-ийн Захирлын 2019 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн Дотоотгушаалын хоёрдугаар хавсралт




ЧАНАРЫН ЗОРИЛТОД ХҮРЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Хүрэх үр дүн	Оролцоо	Дуусах огноо
1	ШУТИС-ийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх	<ul style="list-style-type: none"> Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын шаардлагыг хангах, баталгаажуулах Боловсролын байгууллагын Чанарын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартыг хангах Чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөг үнэлж, тасралтгүй сайжруулах Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг тодорхойлж, нийцлийг үнэлэх, дагаж мөрдөх Чанарын баталгаажуулалтын сайн туршлагыг нэвтрүүлэх Чанарын соёлыг таниулах, сурталчлах Шийдвэр гаргахад эрдэмтэн, судлаачдын оролцоог нэмэгдүүлэх Мэдээлэл, технологийн хэрэглээ, үр ашгийг дээшлүүлэх 	<ol style="list-style-type: none"> Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын баталгаажуулалт хийлгэнэ. Байгууллагын хэмжээнд 2 удаа дотоод аудит хийнэ. Баталгаажуулалтын байгууллагын магадлан аудит хийлгэнэ. Боловсролын байгууллагын Чанарын менежментийн тогтолцооны ISO 21001:2018 стандартын сургалтанд 3 хүртэл хүнийг хамруулж мэргэшүүлнэ. Чанарын менежментийн тогтолцооны үр нөлөөнд нийт ажилтны үзүүлэх хувь нэмэр, үр дагаврыг ойлгуулах арга хэмжээг 2 үе шаттайгаар зохион байгуулна. Чанарын хяналт, үнэлгээний үйл ажиллагааг дэмжих бүртгэл, мэдээллийн цахим системтэй болно. 	<ul style="list-style-type: none"> ЧХШҮА МТТөв 	2020.12
2	ШУТИС-ийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох	<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн брендбүүкийг хөгжүүлэх Байгууллагын сул талыг залруулах Чанарын менежментийн бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> ШУТИС-ийн бодлогын баримт бичгийн нэгдсэн формат, кодтой болно. <ul style="list-style-type: none"> Дүрэм, бодлого Журам Заавар Маягт гэх мэт 	<ul style="list-style-type: none"> ЧХШҮА Бусад нэгж 	2021.12



		<ul style="list-style-type: none"> • ШУТИС-ийн бодлогын баримт бичгийн хүртээмж, үр нөлөөг үнэлэх • Эрх, үүрэг, хариуцлагын хуваарилалтыг оновчтой зохион байгуулахад оролцох • Их сургуулийн засаглалыг бэхжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 2. Бодлогын баримт бичигт үйл явцын аргыг нэвтрүүлнэ. 3. Чанарын менежменттэй холбоотой хэрэгцээт 20 хүртэлх бодлогын баримт бичгийг шинээр эсвэл сайжруулан батлуулна. 4. Их сургуулийн дүрэм, журмын мөрдөлтийг 80%-90% байлга. 5. Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэгдсэн бодлогын баримт бичигтэй нийцүүлнэ. 		
3	Сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> • Үр дүнд суурилсан боловсролыг нэвтрүүлэх • Ажил олгогчдод хэрэгцээтэй ур чадварыг суралцагчид эзэмшүүлэх • Их сургуулийн сургалтын хөтөлбөр болон зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох • Их сургуулийн суралцах, сургах, судлахад таатай орчин, дэд бүтцийн байх ёстой стандартыг тодорхойлж, нийцлийг үнэлэх • Үндэсний болон олон улсын байгууллагын магадлан итгэмжлэлд сургууль, хөтөлбөрийг оруулан сунгах болон шинээр баталгаажуулахыг дэмжих 	<ol style="list-style-type: none"> 1. Сургалтын хөтөлбөрийн боловсруулах, хэрэгжилт болон үр дүнг үнэлэх журмыг шинэчлэн боловсруулж батлуулна. 2. Сургалтын 10 хүртэлх хөтөлбөрийн явц, үр дүнд дотоод чанарын баталгаажуулалтын үнэлгээ хийнэ. 3. Сургалтын анхан шатны үйл явцыг оновчилно. 4. Боломжит нөөцөөр суралцагчдын хувь хүний хөгжилд түлхэц үзүүлэхүйц чанарын орчин, дэд бүтцийг бүрдүүлнэ. 5. Ажил олгогчдын хэрэгцээ, нийгмийн шаардлагыг судалж, мэдээллийн сан үүсгэнэ. 	<ul style="list-style-type: none"> • ЧХШҮА • СБЗГ • СХБА • ОСҮА 	2021.12
4	Хүний нөөцийн сургалт, хөгжлийг дэмжих	<ul style="list-style-type: none"> • Багш, ажилтны чадамжид тавих шаардлагыг тодорхойлох • Чадамжийг үнэлэх арга, аргачлалыг бий болгох • Багш, ажилтны ур чадварыг үнэлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Багш, ажилтны чадамжид тавих шаардлагыг боловсруулж, батлуулна. 2. Их сургуулийн хэмжээнд чадамжийн үнэлгээ хийх ажлыг 1 удаа зохион байгуулна. 	<ul style="list-style-type: none"> • ЧХШҮА • ЗХНГ 	2021.12



		<ul style="list-style-type: none"> • Үнэлгээний мөрөөр шаардлагатай чадамжийг эзэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр нөлөөг үнэлэх • Удирдах албан тушаалтнуудын манлайллын чадавхийг хөгжүүлэх • Багш, оюутнуудыг мэргэжил дээшлүүлэх, гадаад улсад сурах, дадлагажихыг дэмжих 	<ol style="list-style-type: none"> 3. Багш, ажилтны чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хяналт тавьж, үр нөлөөг үнэлнэ. 4. Шинэ ажилтны гарын авлага, дасан зохицуулах хөтөлбөрийг бий болгож, хэрэгжүүлнэ. 		
5	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэх	<ul style="list-style-type: none"> • Хэрэглэгчтэй ойр харилцаатай байх, тэдний хэрэгцээ шаардлагыг ойлгох, мэдрэх <ul style="list-style-type: none"> ○ Хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлс, үзүүлэлтүүдийг олон улсын арга аргачлалын дагуу илрүүлэх • Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг үе шаттайгаар үнэлэх, сэтгэл ханамжгүй шалтгааныг тодорхойлох гүнзгийрүүлсэн судалгаа хийх • Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг өмнөх оны түвшинтэй харьцуулан дүн шинжилгээ хийх • Санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх тогтолцоог хяналттай болгох • Боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн өөрчлөх хувилбарыг санал болгох, боломжит залруулах арга хэмжээг авч, үр нөлөөг хянах 	<ol style="list-style-type: none"> 1. Хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авах нээлттэй, хэрэглэхэд хялбар сувгуудыг бий болгож, нийтэд таниулна. 2. Хэрэглэгчийн санал, гомдол, сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүнгээр нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, сайжруулалт хийх, хянах арга хэмжээг авна. 3. Хэрэглэгчийн гомдлыг ажлын 5 хоногт барагдуулдаг болно. 4. Хэрэглэгчийн бүлэг бүрийн одоогийн сэтгэл ханамжийн түвшингээс 10%-аар дээшлүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • ЧХШҮА • Бусад нэгж 	2020.12



6	Харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	<ul style="list-style-type: none"> Их сургуулийн хамтын ажиллагааны хэрэгцээг тодорхойлох, таатай орчин нөхцлийг бүрдүүлэх Их сургуулийн бүрэлдэхүүн нэгжүүд, багш судлаачид хоорондын хамтын ажиллагааны соёлыг бий болгох Инновацийн экосистемийг бүрдүүлэх Чадварлаг, нарийн мэргэжлийн зочин профессоруудыг урьж ажиллуулах орчин, нөхцөл, бий болгох 	<ol style="list-style-type: none"> Багш, ажилтан, суралцагч, ажил олгогч болон бусад сонирхогч талуудын хоорондох харилцааг холбоог оновчтой зохион байгуулж, хэвшүүлнэ. Инновацийн Экосистемийг бүрдүүлнэ. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> Судалгааны лабораторыг нээлттэйгээр ашиглах боломжийг бүрдүүлж, үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бий болгоно. ШУТИС-ийн материаллаг баазыг түшиглэн бий болсон оюуны бүтээлийг бүртгэлжүүлнэ. Оюуны бүтээлийг олон нийтэд таниулан сурталчилж, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Патент – 3 хүртэл 2. Лицензийн гэрээ - 2 хүртэл 3. Гарааны компани - 2 хүртэл 4. Технологи дамжуулалт 2 хүртэл 	<ul style="list-style-type: none"> ЧХШҮА ЗХНГ ЭШИГ 	2021.12
---	---	---	---	---	---------